

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/06/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)  
Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 92113932 Цахим хаяг: [davaanyamb@audit.gov.mn](mailto:davaanyamb@audit.gov.mn)  
Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88012671 Цахим хаяг: [ichnkhlorlooga@audit.gov.mn](mailto:ichnkhlorlooga@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	17
5.1 Төлбөрийн акт .....	17
5.2 Албан шаардлага .....	17
5.3 Зөвлөмж .....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.23 № 01/281  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА  
ДАРГА Д.ИДЭРМӨНХ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудаас 15 сургуулийн өмнөх боловсролын байгууллага, 8 ерөнхий боловсролын сургууль, 1 насан туршийн боловсролын төв нийт 24 байгууллага улсын төсөвт шилжсэнээр 69,504.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 2,654.1 сая төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 1,120.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч нэр төрлөөр нь авч үзвэл 1,239.3 сая төгрөгөөр тасарсан байна.

#### Бусад асуудлын хэсэг

Мөрөн сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 94.1 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу

илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,985,752.40	1,708,995.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,381,134.60	1,063,979.00
33	АВЛАГА	566,340.90	183,350.60
35	БАРАА МАТЕРИАЛ	3,038,276.90	461,665.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	62,783,836.30	25,006,340.50
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	502,392.20	489,064.20
37300	Урт хугацаат зээл	502,392.20	489,064.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	62,281,444.10	24,517,276.30
39200	Биет хөрөнгө	55,062,515.90	22,272,570.90
39300	Биет бус хөрөнгө	7,218,928.20	2,244,705.40
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	67,769,588.60	26,715,336.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	73,014.50	103,578.60
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	73,014.50	103,578.60
41300	Өглөг	73,014.50	103,578.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	67,696,574.10	26,611,757.40
51	Засгийн газрын хувь оролцоо	67,696,574.10	26,611,757.40
51100	Засгийн газрын оруулсан капитал	19,694,516.50	3,477,869.30
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	19,694,516.50	3,477,869.30
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	19,380.30	19,380.30
51200	Хуримтлагдсан үр дүн	37,496,702.10	22,497,715.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	10,485,975.20	616,792.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	67,769,588.60	26,715,336.00

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	47,659,249.60	14,301,045.20
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,153,534.40	8,507,682.80
110	Орлогын албан татвар	1,649,360.00	7,444,157.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,649,360.00	7,943,092.90
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-498,935.30
113	Хөрөнгийн албан татвар	77,805.50	494,577.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	426,368.80	568,948.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,237,438.60	2,229,402.20
120	Нийтлэг татварын бус орлого	18,237,438.60	2,229,402.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27,268,276.60	3,563,960.10
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	34,625,137.40	16,222,482.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,625,137.40	16,222,482.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,026,033.50	12,934,127.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,547,898.20	1,376,778.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,192,338.50	168,745.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,142,507.40	3,386,980.40
2104	Хангамж, бараа материалын зардал	534,102.50	960,786.60
2105	Нормативт зардал	292,517.70	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	351,074.00	306,806.40
2107	Томилолт, зочны зардал	9,648.20	4,824.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	469,780.60	1,063,333.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,486,166.40	5,665,874.20
212	ТАТААС	1,752,162.00	1,062,694.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	846,941.90	2,225,659.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	13,034,112.20	-1,921,436.80
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,200.00	0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,307,830.30	39,159,240.40
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	11,728,481.90	-41,080,677.20

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	37,790,253.90	13,585,049.70
11	ТАТВАРЫН ОРЛОГО	2,153,534.40	8,507,682.80
110	Орлогын албан татвар	1,649,360.00	7,444,157.60
1100	Хувь хүний орлогын албан татвар	1,649,360.00	7,943,092.90
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-498,935.30
113	Хөрөнгийн албан татвар	77,805.50	494,577.10
118	Бусад татвар, төлбөр, хураамж	426,368.80	568,948.10
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	350,568.40	269,722.40
1181	Газрын төлбөр	73,325.00	296,734.80
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,475.40	2,490.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,530,172.20	1,119,177.70
120	Нийтлэг татварын бус орлого	2,530,172.20	1,119,177.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	33,106,547.30	3,958,189.10
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36,104,344.20	13,359,722.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,104,344.20	13,359,722.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	26,379,644.00	9,323,530.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,614,263.10	1,430,776.20
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,200,922.00	185,029.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,132,081.50	3,386,482.90
2104	Хангамж, бараа материалын зардал	479,646.80	71,256.80
2105	Нормативт зардал	308,422.60	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	419,339.60	306,673.20
2107	Томилолт, зочны зардал	14,444.50	4,824.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	438,061.30	972,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,772,462.60	2,966,237.90
212	ТАТААС	1,752,162.00	1,062,694.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,972,538.20	2,973,496.90
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,685,909.70	225,327.40
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,092,861.30	362,483.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,092,861.30	362,483.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,092,861.30	362,483.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,092,861.30	-362,483.00
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-330,000.00	-180,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	330,000.00	180,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	263,048.40	-317,155.60
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,118,086.20	1,381,134.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,381,134.60	1,063,979.00

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	53,892,601.80	53,892,601.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,071.10	5,071.10
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	53,897,673.00	53,897,673.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-5,311.80	-5,311.80
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,075,731.00	2,075,731.00
9	Тайлант үеийн үр дүн	11,728,481.90	11,728,481.90

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	67,696,574.10	67,696,574.10
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	67,696,574.10	67,696,574.10
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-4,139.50	-4,139.50
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	67,692,434.60	67,692,434.60
19	Тайлант үеийн үр дүн	-41,080,677.20	-41,080,677.20
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	26,611,757.40	26,611,757.40

**2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	9,616,010.6	8,771,938.2	(844,072.4)	91.2
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	8,585,495.6	8,289,032.3	(296,463.3)	96.5
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	6,143,700.2	6,084,162.1	(59,538.1)	99.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,393,057.9	1,376,778.2	(16,279.7)	98.8
210101	Үндсэн цалин	1,230,995.3	1,138,617.6	(92,377.7)	92.5
210102	Нэмэгдэл	51,709.9	127,338.8	75,628.9	246.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,326.6	45,046.7	(21,279.9)	67.9
210104	Урамшуулал	44,026.1	65,775.1	21,749.0	149.4
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	171,216.0	168,745.3	(2,470.7)	98.6
210201	Тэтгэврийн даатгал	115,599.5	114,084.2	(1,515.3)	98.7
210202	Тэтгэмжийн даатгал	14,669.5	13,933.8	(735.7)	95.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,972.6	11,172.0	199.4	101.8
210204	Ажилгүйдлийн даатгал	2,923.8	2,863.8	(60.0)	97.9
210205	Эрүүл мэндийн даатгал	27,050.6	26,691.4	(359.2)	98.7
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	3,404,156.2	3,386,482.9	(17,673.3)	99.5
210301	Гэрэл, цахилгаан	161,316.9	154,802.0	(6,514.9)	96.0
210302	Түлш, халаалт	2,973,349.0	2,964,345.1	(9,003.9)	99.7
210303	Цэвэр, бохир ус	269,490.3	267,335.8	(2,154.5)	99.2
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	62,229.2	61,079.3	(1,149.9)	98.2
210401	Бичиг хэрэг	17,422.0	17,422.0	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	21,200.0	21,199.1	(0.9)	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,857.2	5,412.4	(444.8)	92.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,250.0	17,045.8	(204.2)	98.8
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	310,677.3	310,653.2	(24.1)	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000.0	3,980.0	(20.0)	99.5
210604	Урсгал засвар	306,677.3	306,673.2	(4.1)	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	5,500.0	4,824.0	(676.0)	87.7
210702	Дотоод албан томилолт	3,500.0	2,824.0	(676.0)	80.7
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,000.0	2,000.0	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	492,352.7	481,066.3	(11,286.4)	97.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	486,932.7	476,792.6	(10,140.1)	97.9
210803	Даатгалын үйлчилгээ	300.0	100.0	(200.0)	33.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300.0	249.7	(50.3)	83.2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,700.0	3,924.0	(776.0)	83.5
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	304,510.9	294,532.9	(9,978.0)	96.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	301,510.9	291,699.3	(9,811.6)	96.7

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000.0	2,833.6	(166.4)	94.5
<b>212</b>	<b>ТАТААС</b>	1,062,694.9	1,062,694.9	-	100.0
<b>2121</b>	<b>Төрийн өмчит байгууллагад олгох татаас</b>	1,062,694.9	1,062,694.9	-	100.0
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,062,694.9	1,062,694.9	-	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,379,100.5	1,142,175.3	(236,925.2)	82.8
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	1,327,538.5	1,102,865.5	(224,673.0)	83.1
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,327,538.5	1,102,865.5	(224,673.0)	83.1
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	51,562.0	39,309.8	(12,252.2)	76.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,421.0	16,737.3	(11,683.7)	58.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	23,141.0	22,572.5	(568.5)	97.5
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	404,825.0	302,905.9	(101,919.1)	74.8
223001	Бусад хөрөнгө	404,825.0	302,905.9	(101,919.1)	74.8
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	625,690.0	180,000.0	(445,690.0)	28.8
230001	Эргэж төлөгдөх зээл	625,690.0	180,000.0	(445,690.0)	28.8
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	9,616,010.6	8,788,448.2	(827,562.4)	91.4
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	869,253.8	869,253.8	-	100.0
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	869,253.8	869,253.8	-	100.0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	7,346,411.2	7,658,007.2	311,596.0	104.2
320001	Орон нутгийн төсвөөс	7,346,411.2	7,658,007.2	311,596.0	104.2
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	1,400,345.6	261,187.2	(1,139,158.4)	18.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	340,000.0	243,129.5	(96,870.5)	71.5
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,000.0	18,057.7	8,057.7	180.6

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/ ТЗ цэвэр дүн
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>526,816.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>526,816.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>456,391.28</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>456,391.28</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	456,391.28
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>70,424.92</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,150.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,150.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>66,274.92</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	66,274.92
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>293,005.86</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>293,005.86</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	200,219.50
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,631.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	85,455.36
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-233,810.34</b>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	233,965.03
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	154.69

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:** Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Иргэндээ ээлтэй Мөрөн хотын хөгжлийг бүтээнэ” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажиллаж “Ээлтэй Мөрөн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх жил болгон зарласан байна.

Тус сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 94.1 хувьтай биелүүлж ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:** Тус төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх хяналтыг тавьж ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа байгууллагуудаас Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул 15 сургуулийн өмнөх боловсролын байгууллага, 8 ерөнхий боловсролын сургууль улсын төсөвт шилжсэн байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгжийг Засаг даргын 2022 оны А/36 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын нэгж нь 2022 онд 9 ажил хийхээр төлөвлөж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын орон нутгийн орлого бүрдүүлэлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэл, байгууллагын албан хэрэг хөтлөлт, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

### 3. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:** Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Иргэндээ ээлтэй Мөрөн хотын хөгжлийг бүтээнэ” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажиллаж “Ээлтэй Мөрөн” хөтөлбөрийг хэрэгжүүлэх жил болгон зарласан байна.

Тус сумын Засаг дарга нь нь аймгийн Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 94.1 хувьтай биелүүлж ажилласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:** Тус төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа байгууллагууд нь Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн удирдлагын тухай хууль, Татварын багц хууль болон бусад хууль тогтоомж, журам зааврыг мөрдөн ажилласан байна. Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэх хяналтыг тавьж ажилласан байна.

Тус төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд нийт 43 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна. Үүнээс Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 403 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Боловсролын ерөнхий газрыг байгуулж, 2022 оны 131 дүгээр тогтоолоор Боловсролын ерөнхий газрын даргыг Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсролын, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн төвлөрүүлэн захирагчаар баталсан тул 15 сургуулийн өмнөх боловсролын байгууллага, 8 ерөнхий боловсролын сургууль, 1 насан туршийн боловсролын төв нийт 24 байгууллага улсын төсөвт шилжсэн байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгжийг Засаг даргын 2022 оны А/36 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын нэгж нь 2022 онд 9 ажил хийхээр төлөвлөж, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан харьяа байгууллагуудын орон нутгийн орлого бүрдүүлэлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын гүйцэтгэл, байгууллагын албан хэрэг хөтлөлт, Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголт зэрэг үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын

үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2005 оны 341 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргах зааврын”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41,054.3 сая төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,381.1	1,064.0	(317.2)
Авлага	566.3	183.4	(383.0)
Бараа материал	3,038.3	461.7	(2,576.6)
Урт хугацаат зээл	502.4	489.1	(13.3)
Үндсэн хөрөнгө	62,281.4	24,517.3	(37,764.2)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	67,769.6	26,715.3	(41,054.3)
Өглөг	73.0	103.6	30.6
Засгийн газрын хувь оролцоо	67,696.6	26,611.7	(41,084.8)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	67,769.6	26,715.3	(41,054.3)

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн байдлын тайлан

Тайланд онд мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөр, үндсэн хөрөнгө, бараа материал дансанд дараах хөдөлгөөн хийгдсэн байна. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 317.2 сая төгрөгөөр буурахад Мөрөн Герман хамтын ажиллагааны өмнөх оны дансны үлдэгдэл 233.9 сая төгрөгийг зарцуулсан нь голлох нөлөөг үзүүлсэн байна.
2. Авлага дансны үлдэгдэл 383.0 сая төгрөгөөр буурахад тайлант онд хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлснээр зээлийн авлага 50.6 сая төгрөгөөр буурсан, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага 295.1 сая төгрөгөөр буурсан зэрэг нь нөлөөлсөн байна.  
Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 17 иргэнтэй холбоотой 180.1 сая төгрөг байна.
3. Бараа материалын дансны үлдэгдэл буурахад төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан 8 ерөнхий боловсролын сургууль, 15 сургуулийн өмнөх боловсролын байгууллага, 1 насан туршийн боловсролын байгууллага нийт 24 байгууллага улсын төсөвт шилжсэнээр нийт 2,654.1 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн нь нөлөөлсөн байна. Үүнд: Ерөнхий боловсролын сургуулиуд 1,394.9 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэгүүд 1,251.0 сая төгрөг, насан туршийн боловсролын Гэгээрэл төв 8.2 сая төгрөгийн бараа материалыг тус тус шилжүүлсэн байна.
4. Урт хугацаат зээл 13.3 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд хоршоо хөгжүүлэх сангаас 189.0 сая төгрөгийн зээлийг олгосон байна.
5. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь Ерөнхий боловсролын сургуулиуд 23,306.1 сая төгрөг, хүүхдийн цэцэрлэгүүд 13,166.3 сая төгрөг, насан туршийн боловсролын төв 31.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр улсын төсөвт тус тус шилжүүлсэнтэй холбоотой байна.
6. Барьцаа дансны хугацаа болоогүй чанарын баталгааны өглөг 30.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь өр төлбөр данс өмнөх оны үлдэгдлээс нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

7. Өр төлбөрийн данснаас Ерөнхий боловсролын сургуулийн 1.1 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэгийн 0.2 сая төгрөгийн өглөгийг хасаж тайлагнасан байна.

### Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 14,301.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 33,358.2 сая төгрөгөөр буюу 70 хувиар буурсан байна.

Хүснэгт №2 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого	/сая төгрөг/			
	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү
Татварын орлого	2,153.5	8,507.7	6,354.1	395.1
Татварын бус орлого	18,237.4	2,229.4	(16,008.0)	12.2
Тусламж санхүүжилтийн орлого	27,268.3	3,564.0	(23,704.3)	13.1
<b>Нийт дүн</b>	<b>47,659.2</b>	<b>14,301.0</b>	<b>(33,358.2)</b>	<b>30.0</b>

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлан

Нийт орлогын дүн буурсан шалтгаан нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгийн байгууллагууд улсын төсөвт шилжсэнээр тусламж санхүүжилтийн орлого болон татварын бус орлого буурсантай холбоотой байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 8,111.6 сая төгрөгийн 57 орлогын давхардсан гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 8,004.3 сая төгрөгийн 55 орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

### Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 55,381.7 сая төгрөгийн зардал тайлагнасан байна.

Хүснэгт №3: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал	/сая төгрөг/			
	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү
<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>34,625.08</b>	<b>16,222.49</b>	<b>-18,402.59</b>	<b>46.9</b>
Бараа, ажил үйлчилгээний зардал	32,026.03	12,934.13	-19,091.91	40.4
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,547.90	1,376.78	-15,171.12	8.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,192.34	168.75	-2,023.59	7.7
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,142.51	3,386.98	244.47	107.8
Хангамж, бараа материалын зардал	534.10	960.79	426.68	179.9
Нормативд зардал	292.52	0.00	-292.52	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	351.07	306.81	-44.27	87.4
Томилолт, зочны зардал	9.65	4.82	-4.82	50.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	469.78	1,063.33	593.55	226.3
Бараа үйлчилгээний бусад зардал	8,486.17	5,665.87	-2,820.29	66.8
Татаас	1,752.10	1,062.70	-689.40	60.7
Бусад урсгал шилжүүлэг	846.94	2,225.66	1,378.72	262.8
<b>Үйл ажиллагааны бус зардлын дүн</b>	<b>1,307.83</b>	<b>39,159.24</b>	<b>37,851.41</b>	<b>2994.2</b>
<b>НИЙТ</b>	<b>35,932.91</b>	<b>55,381.73</b>	<b>19,448.82</b>	<b>154.1</b>

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлан

Нийт зардлын дүн өмнөх оноос 19,448.8 сая төгрөгөөр өссөн нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан 24 байгууллага улсын төсөвт шилжиж хаалтын тайлан хийсэнтэй холбоотойгоор үйл ажиллагааны бус зардлын дүн 37,851.4 сая төгрөгөөр нэмэгдэж, үйл ажиллагааны зардал 18,402.6 сая төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 8,111.6 сая төгрөгийн зарлагын давхардсан 57 гүйлгээ, мөнгөн гүйлгээний тайланд 8,004.3 сая төгрөгийн зарлагын давхардсан 55 гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны орлогыг 8,678.1 сая төгрөгөөр төсөвлөж, харьяа байгууллагуудын зардлын төсвийн төслийг 34,026.7 сая төгрөгөөр нэгтгэж аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж ажилласан байна.

Мөрөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 02 дугаар тогтоолоор сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 10,738.9 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Нийт зардлын 918.3 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас, 8,568.7 сая төгрөгийг сумын орон нутгийн орлогоос, 350.0 сая төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, давсан орлого дансны үлдэгдлээс 901.9 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Мөрөн сумын ИТХ-ын 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор төсөвт 637.9 сая төгрөгийн нэмэх тодотгол хийж төсвийг 11,376.9 сая төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

#### Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Мөрөн сумын ИТХ-ын 2022 оны орон нутгийн төсөвт тодотгол хийх тухай 2022 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 1 дүгээр тогтоолд зааснаар Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 8,983.7 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 9,143.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 101.8 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №4. Төвлөрүүлэх орлого

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Зөрүү	Хувь
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	6,220.0	6,601.6	381.6	106.13
Үйл ажиллагааны орлого	251.6	262.1	10.4	104.15
Хөрөнгийн орлого	1,070.0	622.7	(447.3)	58.20
Хөрөнгө борлуулсны орлого	270.0	274.1	4.1	101.51
Шууд бус орлого	179.6	182.6	3.0	101.66
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(498.9)	(498.9)	0.0	100.00
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	330.0	413.4	83.4	125.28
Бууны албан татвар	10.6	10.8	0.2	101.98
Малд ногдуулах албан татвар	50.0	70.3	20.3	140.63
Улсын тэмдэгтийн хураамж	30.0	30.3	0.3	101.11
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	10.0	10.0	0.0	100.25
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	350.1	229.4	(120.8)	65.51
Газрын төлбөр	250.7	252.1	1.4	100.56
Дуудлага худалдаа	-	44.7	44.7	
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.2	0.2	-	100.00
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1.6	1.7	0.1	106.31
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	0.6	0.6	-	100.00
Торгуулийн орлого	457.3	634.8	177.5	138.82
Түрээсийн орлого	0.3	1.3	1.0	517.23
<b>НИЙТ ОРЛОГО</b>	<b>8,983.7</b>	<b>9,143.7</b>	<b>160.1</b>	<b>101.78</b>

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Мөрөн сумын орон нутгийн орлого 160.1 сая төгрөгөөр давж биелэхэд иргэдийн цалин хөлс өссөнөөс цалин хөлс, хөдөлмөр эрхлэлтийн орлого 381.6 сая төгрөгөөр, ААНБ болон иргэдийн худалдан авах чадвар сайжирсантай холбоотойгоор үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар 83.4 сая төгрөгөөр, өмнөх оны малын албан татварын ногдлыг тайлант онд төлүүлсэнтэй холбоотойгоор малд ногдуулах албан татвар 20.3 сая төгрөгөөр, Газрын дуудлага худалдааны орлогын 40 хувийг суманд төвлөрүүлэх аймгийн ИТХ-ын тогтоол гарсантай холбоотойгоор дуудлага худалдааны орлого 44.7 сая төгрөгөөр, хяналт шалгалтын үр дүнгээс хамааран торгуулийн орлого 177.5 сая төгрөгөөр давж биелсэн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Хөрөнгийн орлого 447.3 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамж 120.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 2,748.4 сая төгрөгөөр төлөвлөж 3,101.2 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 352.8 сая төгрөг буюу 13 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №5: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ААНОАТ /40/	895.3	906.2	10.9
2	АТБӨЯХ	367.8	388.6	20.7
3	Зам ашигласны төлбөр	84.7	94.2	9.5
4	Улсын тэмдэгтийн хураамж	224.0	281.5	57.5
5	Газрын үл хөдлөх хөрөнгийн татвар		0.7	0.7
6	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	13.8	20.8	7.0
7	Татварын торгууль	310.0	79.2	-230.8
8	Татварын алданги		32.6	32.6
9	Татварын бус хүү торгуулийн орлого		555.9	555.9
10	Хөрөнгө худалдсаны орлого	717.0	439.1	-277.9
11	Түрээсийн орлого	3.5	35.8	32.2
12	Газрын суурь хураамж		97.4	97.4
13	Нэр заагдаагүй бусад орлого	132.2	169.1	36.9
<b>Нийт дүн</b>		<b>2,748.4</b>	<b>3,101.2</b>	<b>352.8</b>

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл татварын торгуулийг 230.8 сая төгрөгөөр, хөрөнгө худалдсаны орлого 277.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

**Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:** Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 4,347.6 сая төгрөгөөр төлөвлөж 4,955.6 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 608.0 сая төгрөгөөр буюу 14 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №6: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	ААНОАТ	1,183.1	1,046.5	-136.6
2	Суутгасан ААНОАТ	0.0	232.2	232.2
3	НӨАТатвар	2,997.9	3,459.2	461.3
4	Онцгой албан татвар	85.0	156.7	71.7
5	Ашигт малтмал/нүүрс	0.0	3.2	3.2
6	Ус бохирдуулсны төлбөр	3.5	5.6	2.1
7	Агаарын бохирдол /авто/	75.1	49.2	-25.9
8	Агаарын бохирдол /эх үүсвэр/	3.0	3.0	0.0
<b>Нийт дүн</b>		<b>4,347.6</b>	<b>4,955.6</b>	<b>608.0</b>

Эх сурвалж: Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл ААНОАТ 136.6 сая төгрөгөөр, агаарын бохирдлын татвар 25.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

#### Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 1,319.2 сая төгрөгөөр төлөвлөж, 1,230.4 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 93.2 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс: Сум хөгжүүлэх сангийн зээлийн хүү болон эргэн төлөлтөөс 350.0 сая төгрөгийг орлогыг оруулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 261.2 сая төгрөгийн хүүгийн төлбөр болон зээлийн эргэн төлөлтийн орлогыг төвлөрүүлсэн байна.

#### Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрт зориулан 9,616.0 сая төгрөгийг, аймгийн төсөвт төвлөрүүлэхээр 1,760.9 сая төгрөгийг нийт 11,376.9 сая төгрөгөөр төсвийн зарлагыг баталсан байна. Үүнээс 7,679.4 сая төгрөгийг урсгал зардалд, 1,311.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 625.7 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 7,419.8 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 1,172.1 сая төгрөгийг, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардалд 180.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,771.9 сая төгрөг буюу 91.2 хувьтай байна.

Хүснэгт №6 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	9,616.0	8,771.9	(844.1)	91.2
Урсгал зардал	8,585.5	8,289.0	(296.5)	96.5
Бараа, ажил үйлчилгээний зардал	6,143.7	6,084.2	(59.5)	99.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,393.1	1,376.8	(16.3)	98.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	171.2	168.7	(2.5)	98.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,404.2	3,386.5	(17.7)	99.5
Хангамж, бараа материалын зардал	62.2	61.1	(1.1)	98.2
Эд хогшил, урсгал засварын зардал	310.7	310.7	(0.0)	100.0
Томилолт, зочны зардал	5.5	4.8	(0.7)	87.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	492.4	481.1	(11.3)	97.7
Бараа үйлчилгээний бусад зардал	304.5	294.5	(10.0)	96.7
Татаас	1,062.7	1,062.7	-	100.0
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	1,062.7	1,062.7	-	100.0
Урсгал шилжүүлэг	1,379.1	1,142.2	(236.9)	82.8
Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,327.5	1,102.9	(224.7)	83.1
Бусад урсгал шилжүүлэг	51.6	39.3	(12.3)	76.2
Хөрөнгийн зардал	404.8	302.9	(101.9)	74.8
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	625.7	180.0	(445.7)	28.8

Батлагдсан төсвөөс 844.1 сая төгрөгийг зарцуулаагүй нь хоршоо хөгжүүлэх сангаас олгохоор төлөвлөсөн 445.7 сая төгрөгийн зээлийг олгоогүй, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр батлагдсан 5 төсөл арга хэмжээ тайлант онд хэрэгжээгүйгээс 224.7 сая төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансны эхний үлдэгдэл 233.9 сая төгрөг байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагууд нь хандив тусламжаар 200.2 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 5.6 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 1.7 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 85.5 сая төгрөг нийт 293.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 456.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орлогын биелэлт болон хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Давааням аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Мөрөн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/173 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2.0 хувиар тогтоож сонгосон суурь үзүүлэлтээс тооцож 692.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 554.0 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяанд байсан байгууллагууд улсын төсөвт шилжсэнтэй холбоотойгоор материаллаг байдлын түвшнийг тайлант оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 16,222.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 324.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 259.6 сая төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлэхэд Мөрөн сумын ЗДТГ-аас 15.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд тайлант онд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 7 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	220.6	3	220.6	100
Нийт дүн	3	220.6	3	220.6	100.0

/сая төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах асуудал илрээгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлого болон харьяа 30 төсвийн байгууллага, 5 тусгай сан, 7 ОНӨААТҮГ-ийн нийт 43 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 31 байгууллагад дүгнэлт гаргаж, 12 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан бүгд “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан байна. Тайлант онд боловсролын салбарын 24 байгууллага улсын төсөвт шилжсэн тул хаалтын тайлан гаргаж нэгтгэсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,311.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 2,153.2 сая төгрөгийн 2 алдааг залруулж 31.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 15.4 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 112.3 сая төгрөгийн 9 зөвлөмжийг өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 1,138.5 сая төгрөгийн алдааг илрүүлж аудитын хугацаанд бүрэн залруулсан. Үүнд:

- Харьяа байгууллагуудын үр дүнгийн тайланг 26.2 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн.
- ОНХС болон ОНХО-ийн тайланг 1,004.9 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн.
- Санхүүгийн үр дүнгийн тайланд хоорондын тооцооны бичилтийг 107.4 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн.

Аудитаар төсөвт төвлөрүүлэх орлогын бүрдэлт болон хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлттэй холбоотой 1,419.4 сая төгрөгийн зөрчил илэрч 3 зөвлөмжийг хүргүүлж байна.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргүүлээгүй болно.

#### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нийт дүнгээр нь 1,120.9 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч нэр төрлөөр нь авч үзвэл 1,239.3 сая төгрөгөөр тасарсан

байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, гүйцэтгэлийг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

2. **Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлтэй холбоотой асуудал**

2.1. Илрүүлэлт:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн 17 иргэнтэй холбоотой 180.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 361 дүгээр тушаалаар баталсан "хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.2.1."орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, хоршоо хөгжүүлэх бодлоготой уялдуулан тогтоож, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг бүрэн барагдуулж ажиллах.

3. **Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар**

3.1. Илрүүлэлт:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 2,311.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Аудитын хугацаанд 2,153.2 сая төгрөгийн 2 алдааг залруулж 31.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 15.4 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 112.3 сая төгрөгийн 9 зөвлөмжийг өгсөн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. **АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөрөн сумын ТТЗ	5	1138.5			5	1138.5	5	1138.5				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>1138.5</b>			<b>5</b>	<b>1138.5</b>	<b>5</b>	<b>1138.5</b>				
Харьяа байгууллагуудын алдаа												
Мөрөн сумын ЗДТГ	2	2,153.2			2	2,153.2	2	2,153.2				
<b>ДҮН</b>	<b>2</b>	<b>2,153.2</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>2,153.2</b>	<b>2</b>	<b>2,153.2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>нийт дүн</b>	<b>7</b>	<b>2,153.2</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>2,153.2</b>	<b>2</b>	<b>2,153.2</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөрөн ТТЗ	3	1419.4					3	1419.4				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1419.4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>3</b>	<b>1419.4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
Харьяа байгууллагуудын зөрчил												
Мөрөн сумын ЗДТГ	1	15.4			1	15.4						
Мөрөн сумын ИТХ	1	31.0	1	31.0								
Дэлгэрмөрөн ӨЭМТ	1	12.7					1	12.7				
Энэрэл ӨЭМТ	1	7.0					1	7.0				
Энх-Үйлс ӨЭМТ	1	1.7					1	1.7				
Гурван гал ӨЭМТ	1	3.3					1	3.3				
Далайн элбэрэлт ӨЭМТ	1	5.6					1	5.6				
<b>Дүн</b>	<b>7</b>	<b>76.7</b>	<b>1</b>	<b>31.0</b>	<b>1</b>	<b>15.4</b>	<b>5</b>	<b>30.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>1,496.1</b>	<b>1</b>	<b>31.0</b>	<b>1</b>	<b>15.4</b>	<b>8</b>	<b>1,449.7</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Мөрөн ТТЗ	0	-						
Харьяа байгууллагуудын зөрчил								
Дэлгэрмөрөн ӨЭМТ	1	21,474.7					1	21,474.7
Энэрэл ӨЭМТ	1	30,896.0					1	30,896.0
Энх-Үйлс ӨЭМТ	1	12,744.0					1	12,744.0
Далайн элбэрэлт ӨЭМТ	1	16,923.6					1	16,923.6
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>82,038.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>4</b>	<b>82,038.3</b>
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>82,038.3</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>4</b>	<b>82,038.3</b>

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЫМ ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО: